



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Нам хүчдэлийн цахилгаан байгууламж
5-56 дугаар хэсэг: Цахилгаан тоног төхөөрөмжийг сонгох ба угсрах –
Аюулгүй ажиллагааны үйлчилгээ

Low-voltage electrical installations
Part 5-56: Selection and erection of electrical equipment –
Safety services

MNS IEC 60364-5-56:20XX

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот
20XX он

MNS IEC 60364-5-56:20XX

Энэ стандартыг орчуулж,
..... шүүмж, редакц хийж, хянасан.

Анхны үзлэгийг онд, дараа нь 5 жил тутамд хийнэ.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Шуудангийн хаяг

Улаанбаатар-13343, Ш/Х - 48

Утас: 976-51-263860 Факс: 976-11-458032

E-mail: masm@mongol.net; standardinform@masm.gov.mn

www.estandard.mn; www.masm.gov.mn

© СХЗГ, 20XX

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай”
Монгол Улсын хууль болон холбогдох эрх зүйн зохицуулалтын дагуу энэхүү
стандартыг бүрэн эсхүл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь стандартчиллын төв
байгууллагад байна.

АГУУЛГА

Өмнөх үг	4
560.1 Хамрах хүрээ	8
560.2 Норматив эшлэл	8
560.3 Нэр томъёо ба тодорхойлолт	9
560.4 Ангилал	11
560.5 Ерөнхий шаардлага	11
560.6 Аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан эх үүсвэр	12
560.7 Аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан хэлхээ	14
560.8 Утас, кабелийн систем	16
560.9 Ослын гэрэлтүүлгийн хэрэглээ	17
560.10 Галын хамгаалалтын хэрэглээ/тоног төхөөрөмж	20
A хавсралт (мэдээллийн) – Ослын гэрэлтүүлгийн удирдамж	21
B хавсралт (мэдээллийн) – Аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжийн удирдамж	22
C хавсралт (мэдээллийн) – Зарим улсын тухай тайлбарын жагсаалт	23
D хавсралт (мэдээллийн) – Галын унтраалга	27
E хавсралт (мэдээллийн) – Кабель удирдлагын системтэй аюулгүй ажиллагааны үйлчилгээг угсрах аргын жишээ	28
F хавсралт (мэдээллийн) – Утас, кабелийн систем	29
G хавсралт (мэдээллийн) – Аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан эх үүсвэрийн тохирох байршлын удирдамж	32
Ном зүй	33

CONTENTS

Foreword	4
560.1 Scope	8
560.2 Normative references	8
560.3 Terms and definitions	9
560.4 Classification	11
560.5 General	11
560.6 Electrical sources for safety services	12
560.7 Electrical circuits of safety services	14
560.8 Wiring systems	16
560.9 Emergency lighting applications	17
560.10 Fire protection applications/equipment	20
Annex A (informative) – Guidance for emergency lighting	21
Annex B (informative) – Guidance for safety equipment	22
Annex C (informative) – List of notes concerning certain countries	23
Annex D (informative) – Fire switch	27
Annex E (informative) – Example of installation methods of safety services with cable management system	28
Annex F (informative) – Wiring systems	29
Annex G (informative) – Guidance on suitable locations for electrical sources for safety services	32
Bibliography	33

ОЛОН УЛСЫН ЦАХИЛГААН ТЕХНИКИЙН КОМИСС

**НАМ ХҮЧДЭЛИЙН ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖ –
5-56 дугаар хэсэг: Цахилгаан тоног төхөөрөмжийг сонгох ба угсрах –
Аюулгүй ажиллагааны үйлчилгээ**

ӨМНӨХ ҮГ

1) Олон Улсын Цахилгаан Техникийн Комисс (IEC) нь үндэсний цахилгаан техникийн бүх хороодоос (IEC-ийн Үндэсний хороод) бүрдсэн дэлхий нийтийн стандартчиллын байгууллага юм. IEC-ийн зорилго нь цахилгаан ба электроникийн салбарын стандартчилалтай холбоотой бүх асуудлаар олон улсын хамтын ажиллагааг дэмжихэд оршино. Энэ зорилгын хүрээнд болон бусад үйл ажиллагааны зэрэгцээ IEC нь Олон улсын стандарт, Техникийн тодорхойлолт, Техникийн тайлан, Нийтэд нээлттэй тодорхойлолт (PAS), гарын авлага (цаашид “IEC-ийн хэвлэл(үүд)” гэх)-ыг хэвлэн нийтэлдэг. Тэдгээрийг боловсруулах ажлыг техникийн хороод гүйцэтгэх бөгөөд тухайн сэдвийг сонирхсон IEC-ийн аливаа Үндэсний хороо бэлтгэл ажилд оролцож болно. IEC-тэй хамтран ажилладаг олон улсын, төрийн болон төрийн бус байгууллагууд мөн бэлтгэл ажилд оролцоно. IEC нь хоёр байгууллагын хооронд тохиролцсон нөхцөлийн дагуу Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-тай нягт хамтран ажилладаг.

2) Техникийн асуудлаарх IEC-ийн албан ёсны шийдвэр буюу тохиролцоо нь холбогдох сэдвийн талаархи олон улсын санал нэгдлийг аль болох бодитоор илэрхийлдэг. Учир нь техникийн хороо бүрт сонирхогч бүх IEC-ийн Үндэсний хороодын төлөөлөл оролцдог.

3) IEC-ийн хэвлэлүүд нь олон улсад хэрэглэх зөвлөмжийн хэлбэртэй бөгөөд IEC-ийн Үндэсний хороод тэдгээрийг энэ утгаар хүлээн зөвшөөрдөг. IEC-ийн хэвлэлийн техникийн агуулгын үнэн зөв байдлыг хангахын тулд боломжит бүх зохистой арга хэмжээг авдаг боловч тэдгээрийг хэрхэн ашигласан, эсхүл эцсийн хэрэглэгч хэрхэн буруу тайлбарласанд IEC хариуцлага хүлээхгүй.

4) Олон улсын нэгдмэл байдлыг дэмжихийн тулд IEC-ийн Үндэсний хороод IEC-ийн хэвлэлийг үндэсний болон бүс нутгийн хэвлэлдээ боломжит дээд хэмжээнд ил тод хэрэглэнэ. IEC-ийн хэвлэл ба түүнд харгалзах үндэсний буюу бүс нутгийн хэвлэлийн аливаа зөрүүг сүүлийн баримт бичигт тодорхой заана.

MNS IEC 60364-5-56:20XX

5) IEC өөрөө тохирлын баталгаа олгодоггүй. Бие даасан баталгаажуулалтын байгууллагууд тохирлын үнэлгээний үйлчилгээ үзүүлж, зарим салбарт IEC-ийн тохирлын тэмдэг ашиглах боломж олгодог. Бие даасан баталгаажуулалтын байгууллагын үзүүлсэн аливаа үйлчилгээний төлөө IEC хариуцлага хүлээхгүй.

6) Бүх хэрэглэгч энэхүү хэвлэлийн хамгийн сүүлийн хэвлэлийг ашиглаж байгаа эсэхээ нягтална.

7) Энэхүү IEC-ийн хэвлэл болон бусад IEC-ийн хэвлэлийг нийтлэх, ашиглах, түүнд тулгуурласнаас үүдсэн шууд буюу шууд бус аливаа биеийн гэмтэл, эд хөрөнгийн хохирол, бусад хохирол, зардал (хууль зүйн төлбөрийг оролцуулан) болон бусад зарлагын талаар IEC, түүний захирал, ажилтан, албан хаагч, төлөөлөгч, түүний дотор техникийн хороод ба IEC-ийн Үндэсний хороодын шинжээч, гишүүд ямар ч хариуцлага хүлээхгүй.

8) Энэхүү хэвлэлд эш татсан норматив баримт бичгүүдэд анхаарна. Тэдгээрийг хэрэглэх нь энэхүү хэвлэлийг зөв хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай.

9) Энэхүү IEC-ийн хэвлэлийн зарим элементийн хувьд патентын эрх хамаарч болохыг анхаарна. Ийм патентын эрхийг бүхэлд нь буюу хэсэгчлэн тогтоох үүргийг IEC хүлээхгүй.

IEC 60364-5-56 Олон улсын стандартыг IEC-ийн 64 дүгээр техникийн хороо “Цахилгаан байгууламж ба цахилгаан гүйдэлд нэрвэгдэхээс хамгаалах” боловсруулсан.

Энэхүү гурав дахь хэвлэл нь 2009 онд хэвлэгдсэн хоёр дахь хэвлэлийг хүчингүй болгож, орлоно. Энэ хэвлэл нь техникийн шинэчилсэн найруулга юм.

Өмнөх хэвлэлтэй харьцуулахад дараах техникийн гол өөрчлөлтүүдийг оруулсан: 1) Норматив эшлэл, нэр томьёо ба тодорхойлолтыг өөрчилсөн. 2) Галын нөхцөлд аюулгүй ажиллагааны үйлчилгээний тэжээлийн найдвартай байдлыг хадгалах хэлхээ ба хэт гүйдлийн хамгаалалтын шаардлагыг нэмсэн. 3) Аюулгүй ажиллагааны үйлчилгээний хэлхээг RCD эсхүл AFDD-ээр хамгаалахгүй байх шаардлагыг нэмсэн. 4) Удирдлагын систем ослын гэрэлтүүлэгт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх шаардлагыг нэмсэн. 5) Эцсийн хэлхээний гэмтлийн үед тухайн бүсийн бүх ослын гэрэлтүүлэгч бүрэн зураг төслийн гэрлийн гаралт өгөх шаардлагыг нэмсэн. 6) D хавсралт “Галын унтраалга”-ыг нэмсэн. 7) E хавсралт “Кабель удирдлагын системтэй аюулгүй ажиллагааны үйлчилгээг угсрах аргын жишээ”-г нэмсэн. 8) F хавсралт “Утас, кабелийн систем”-ийг нэмсэн. 9) G хавсралт “Аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан эх үүсвэрийн тохирох байршлын удирдамж”-ийг нэмсэн.

Энэхүү Олон улсын стандартын бичвэр 64/2316/FDIS баримт бичиг болон 64/2341/RVD санал хураалтын тайланд үндэслэсэн. Баталсан санал хураалтын бүрэн мэдээллийг дээрх тайлангаас үзэж болно.

Энэ баримт бичгийг ISO/IEC Directives, Part 2-ын дагуу боловсруулсан.

C хавсралтад энэ стандартын сэдэвтэй холбоотой зарим улсын ялгаатай практикийг тусгасан бүх “зарим улсад” заалтыг жагсаасан.

“Low-voltage electrical installations” ерөнхий нэрийн дор хэвлэгдсэн IEC 60364 цувралын бүх хэсгийн жагсаалтыг IEC-ийн цахим хуудаснаас үзэж болно.

Хороо энэхүү баримт бичгийн агуулгыг IEC-ийн цахим хуудсанд заасан тогтвортой байдлын огноо хүртэл өөрчлөхгүй байхаар шийдвэрлэсэн. Тэр огноонд баримт бичгийг дахин баталгаажуулах, хүчингүй болгох, шинэчилсэн хэвлэлээр солих эсхүл нэмэлт өөрчлөлт оруулна.

Энэ хэвлэлийн хоёр хэлээрх хувилбарыг дараа нь гаргаж болно.

INTERNATIONAL ELECTROTECHNICAL COMMISSION

LOW-VOLTAGE ELECTRICAL INSTALLATIONS –

Part 5-56: Selection and erection of electrical equipment – Safety services

FOREWORD

1) The International Electrotechnical Commission (IEC) is a worldwide organization for standardization comprising all national electrotechnical committees (IEC National Committees). The object of IEC is to promote international co-operation on all questions concerning standardization in the electrical and electronic fields. To this end and in addition to other activities, IEC publishes International Standards, Technical Specifications, Technical Reports, Publicly Available Specifications (PAS) and Guides (hereafter referred to as “IEC Publication(s)”). Their preparation is entrusted to technical committees; any IEC National Committee interested in the subject dealt with may participate in this preparatory work. International, governmental and non-governmental organizations liaising with the IEC also participate in this preparation. IEC collaborates closely with the International Organization for Standardization (ISO) in accordance with conditions determined by agreement between the two organizations.

2) The formal decisions or agreements of IEC on technical matters express, as nearly as possible, an international consensus of opinion on the relevant subjects since each technical committee has representation from all interested IEC National Committees.

3) IEC Publications have the form of recommendations for international use and are accepted by IEC National Committees in that sense. While all reasonable efforts are made to ensure that the technical content of IEC Publications is accurate, IEC cannot be held responsible for the way in which they are used or for any misinterpretation by any end user.

4) In order to promote international uniformity, IEC National Committees undertake to apply IEC Publications transparently to the maximum extent possible in their national and regional publications. Any divergence between any IEC Publication and the corresponding national or regional publication shall be clearly indicated in the latter.

MNS IEC 60364-5-56:20XX

5) IEC itself does not provide any attestation of conformity. Independent certification bodies provide conformity assessment services and, in some areas, access to IEC marks of conformity. IEC is not responsible for any services carried out by independent certification bodies.

6) All users should ensure that they have the latest edition of this publication.

7) No liability shall attach to IEC or its directors, employees, servants or agents including individual experts and members of its technical committees and IEC National Committees for any personal injury, property damage or other damage of any nature whatsoever, whether direct or indirect, or for costs (including legal fees) and expenses arising out of the publication, use of, or reliance upon, this IEC Publication or any other IEC Publications.

8) Attention is drawn to the Normative references cited in this publication. Use of the referenced publications is indispensable for the correct application of this publication.

9) Attention is drawn to the possibility that some of the elements of this IEC Publication may be the subject of patent rights. IEC shall not be held responsible for identifying any or all such patent rights.

International Standard IEC 60364-5-56 has been prepared by IEC technical committee 64: Electrical installations and protection against electric shock.

This third edition cancels and replaces the second edition published in 2009. This edition constitutes a technical revision.

This edition includes the following significant technical changes with respect to the previous edition: 1) Modifications to normative references and terms and definitions. 2) Addition of requirements concerning circuit and overcurrent protection to maintain reliability of safety service power supplies under fire conditions. 3) Addition of requirements stating that circuits for safety services are not to be protected by RCDs or AFDDs. 4) Addition of requirements to prevent emergency lighting systems being adversely affected by any control system. 5) Addition of requirements for all emergency luminaires in the area to provide full design light output in the event of any final circuit failure. 6) New Annex D: Fire switch. 7) New Annex E: Example of installation methods of safety services with cable management system. 8) New Annex F: Wiring systems. 9) New Annex G: Guidance on suitable locations for electrical sources for safety services.

The text of this International Standard is based on the following documents: FDIS 64/2316/FDIS; Report on voting 64/2341/RVD. Full information on the voting for the approval of this International Standard can be found in the report on voting indicated above.

This document has been drafted in accordance with the ISO/IEC Directives, Part 2.

The reader's attention is drawn to the fact that Annex C lists all of the "in-some-country" clauses on differing practices of a less permanent nature relating to the subject of this standard.

A list of all parts in the IEC 60364 series, published under the general title Low-voltage electrical installations, can be found on the IEC website.

The committee has decided that the contents of this document will remain unchanged until the stability date indicated on the IEC website. At this date, the document will be reconfirmed, withdrawn, replaced by a revised edition, or amended.

A bilingual version of this publication may be issued at a later date.

МОНГОЛ	ENGLISH
НАМ ХҮЧДЭЛИЙН ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖ 5-56 дугаар хэсэг: Цахилгаан тоног төхөөрөмжийг сонгох ба угсрах – Аюулгүй ажиллагааны үйлчилгээ	LOW-VOLTAGE ELECTRICAL INSTALLATIONS Part 5-56: Selection and erection of electrical equipment – Safety services
560.1 Хамрах хүрээ IEC 60364-ийн энэ хэсэг нь аюулгүй ажиллагааны үйлчилгээний ерөнхий шаардлага, аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан хангамжийн систем болон аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан эх үүсвэрийг сонгох ба угсрах шаардлагыг хамарна. Нөөц цахилгаан хангамжийн систем нь энэ баримт бичгийн хамрах хүрээнд хамаарахгүй. Энэ баримт бичгийг аюултай бүс (BE3)-ийн байгууламжид хэрэглэхгүй бөгөөд тэдгээрийн шаардлагыг IEC 60079-14-т тогтоосон.	560.1 Scope This part of IEC 60364 covers general requirements for safety services, selection and erection of electrical supply systems for safety services and the electrical source for safety services. Standby electrical supply systems are outside the scope of this document. This document does not apply to installations in hazardous areas (BE3), for which requirements are given in IEC 60079-14.
560.2 Норматив эшлэл Дараах баримт бичгүүдийг энэ баримт бичгийн бичвэрт бүхэлд нь эсхүл хэсэгчлэн шаардлага болох байдлаар эш татсан. Огноотой эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Огноогүй эшлэлийн хувьд эш татсан баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэлийг (түүний бүх нэмэлт өөрчлөлтийг оролцуулан) хэрэглэнэ. IEC 60331 (бүх хэсэг), Галын нөхцөл дэх цахилгаан кабелийн туршилт – Хэлхээний бүрэн бүтэн байдал IEC 60332-1-2, Галын нөхцөл дэх цахилгаан ба оптик шилэн кабелийн туршилт – 1-2 дугаар хэсэг: Нэг тусгаарлагатай утас буюу кабелийн босоо дөл тархалтын туршилт – 1 kW-ийн урьдчилан холисон дөлөөр турших арга IEC 60364-4-41:2005, Нам хүчдэлийн цахилгаан байгууламж – 4-41 дүгээр хэсэг: Аюулгүй байдлын хамгаалалт – Цахилгаан гүйдэлд нэрвэгдэхээс хамгаалах IEC 60364-5-52, Нам хүчдэлийн цахилгаан байгууламж – 5-52 дугаар хэсэг: Цахилгаан тоног төхөөрөмжийг	560.2 Normative references The following documents are referred to in the text in such a way that some or all of their content constitutes requirements of this document. For dated references, only the edition cited applies. For undated references, the latest edition of the referenced document (including any amendments) applies. IEC 60331 (all parts), Tests for electric cables under fire conditions – Circuit integrity IEC 60332-1-2, Tests on electric and optical fibre cables under fire conditions – Part 1-2: Test for vertical flame propagation for a single insulated wire or cable – Procedure for 1 kW pre-mixed flame IEC 60364-4-41:2005, Low-voltage electrical installations – Part 4-41: Protection for safety – Protection against electric shock IEC 60364-5-52, Low-voltage electrical installations – Part 5-52: Selection and erection of electrical equipment – Wiring systems IEC 60598-2-22, Luminaires – Part 2-22: Particular requirements – Luminaires for

сонгох ба угсрах – Утас, кабелийн систем IEC 60598-2-22, Гэрэлтүүлэгч – 2-22 дугаар хэсэг: Тусгай шаардлага – Ослын гэрэлтүүлгийн гэрэлтүүлэгч IEC 60702-1, 750 V-оос ихгүй хэвийн хүчдэлтэй эрдэс тусгаарлагатай кабель ба түүний төгсгөвч – 1 дүгээр хэсэг: Кабель IEC 60702-2, 750 V-оос ихгүй хэвийн хүчдэлтэй эрдэс тусгаарлагатай кабель ба түүний төгсгөвч – 2 дугаар хэсэг: Төгсгөвч IEC 62040-1, Тасралтгүй цахилгаан хангамжийн систем (UPS) – 1 дүгээр хэсэг: Аюулгүй байдлын шаардлага IEC 62040-2, Тасралтгүй цахилгаан хангамжийн систем (UPS) – 2 дугаар хэсэг: Цахилгаан соронзон нийцлийн (EMC) шаардлага IEC 62040-3, Тасралтгүй цахилгаан хангамжийн систем (UPS) – 3 дугаар хэсэг: Гүйцэтгэл ба туршилтын шаардлагыг тодорхойлох арга ISO 8528-12, Дотоод шаталтын поршен хөдөлгүүрээр ажилладаг хувьсах гүйдлийн генераторын агрегат – 12 дугаар хэсэг: Аюулгүй ажиллагааны үйлчилгээнд зориулсан ослын цахилгаан хангамж ISO 30061:2007, Ослын гэрэлтүүлэг	emergency lighting IEC 60702-1, Mineral insulated cables and their terminations with a rated voltage not exceeding 750 V – Part 1: Cables IEC 60702-2, Mineral insulated cables and their terminations with a rated voltage not exceeding 750 V – Part 2: Terminations IEC 62040-1, Uninterruptible power systems (UPS) – Part 1: Safety requirements IEC 62040-2, Uninterruptible power systems (UPS) – Part 2: Electromagnetic compatibility (EMC) requirements IEC 62040-3, Uninterruptible power systems (UPS) – Part 3: Method of specifying the performance and test requirements ISO 8528-12, Reciprocating internal combustion engine driven alternating current generating sets – Part 12: Emergency power supply to safety services ISO 30061:2007, Emergency lighting
560.3 Нэр томьёо ба тодорхойлолт Энэ баримт бичгийн зорилгоор дараах нэр томьёо ба тодорхойлолтыг хэрэглэнэ. 560.3.1 аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан хангамжийн систем – цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн зайлшгүй хэсгүүдийн ажиллагааг хүн ба малын эрүүл мэнд, аюулгүй байдалд зориулан болон/эсхүл хүрээлэн буй орчин, бусад тоног төхөөрөмжид хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор хадгалах хангамжийн систем. Бичилтийн 1-р тайлбар: Хангамжийн системд эх үүсвэр болон цахилгаан тоног төхөөрөмжийн хавчаар хүртэлх цахилгаан хэлхээ багтана.	560.3 Terms and definitions For the purposes of this document, the following terms and definitions apply. 560.3.1 electrical supply system for safety services – supply system intended to maintain the operation of essential parts of an electrical installation and equipment – for the health and safety of persons and livestock, and/or – to avoid damage to the environment and to other equipment. Note 1 to entry: The supply system includes the source and the electrical circuits up to the terminals of electrical equipment. 560.3.2 electrical source for safety services – electrical source intended to be used as part of an electrical supply system for safety services.

560.3.2 аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан эх үүсвэр – аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан хангамжийн системийн хэсэг болгон ашиглах зориулалттай цахилгаан эх үүсвэр. 560.3.3 аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан хэлхээ – аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан хангамжийн системийн хэсэг болгон ашиглах зориулалттай цахилгаан хэлхээ. 560.3.4 нөөц цахилгаан хангамжийн систем – хэвийн тэжээл тасарсан үед аюулгүй байдлаас өөр шалтгаанаар цахилгаан байгууламж буюу түүний хэсгийн ажиллагааг хадгалах хангамжийн систем. 560.3.5 нөөц цахилгаан эх үүсвэр – хэвийн тэжээл тасарсан үед аюулгүй байдлаас өөр шалтгаанаар цахилгаан байгууламж буюу түүний хэсгийн тэжээлийг хадгалах цахилгаан эх үүсвэр. 560.3.6 ослын гэрэлтүүлэг – хэвийн гэрэлтүүлгийн тэжээл тасарсан үед ашиглах гэрэлтүүлэг. [ЭХ СУРВАЛЖ: ISO 30061:2007, 4.1] 560.3.7 ослын гэрэлтүүлгийн гэрэлтүүлэгч – өөрийн аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан эх үүсвэртэй эсхүл эх үүсвэргүй байж болох, аюулгүй буюу ослын гэрэлтүүлэгт ашиглах гэрэлтүүлэгч. 560.3.8 нүүлгэн шилжүүлэх чиглэлийн тэмдэглэгээний гэрэлтүүлэгч – нүүлгэн шилжүүлэх замыг зааж, танихад туслах гэрэлтүүлэгч. 560.3.9 байнгын ажиллагааны горим – хэвийн буюу ослын гэрэлтүүлэг шаардлагатай бүх хугацаанд ослын гэрэлтүүлгийн чийдэн тэжээлтэй байх горим. 560.3.10 байнгын бус ажиллагааны горим – хэвийн гэрэлтүүлгийн тэжээл тасарсан үед л ослын гэрэлтүүлгийн чийдэн ажиллах горим. 560.3.11 хариу үйлдлийн хугацаа – хэвийн цахилгаан хангамж гэмтсэнээс аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан эх үүсвэр тоног төхөөрөмжийг	560.3.3 electrical circuits for safety services – electrical circuits intended to be used as part of an electrical supply system for safety services. 560.3.4 standby electrical supply system – supply system intended to maintain, for reasons other than safety, the functioning of an electrical installation or parts thereof, in case of interruption of the normal supply. 560.3.5 standby electrical source – electrical source intended to maintain, for reasons other than safety, the supply to an electrical installation or parts thereof, in case of interruption of the normal supply. 560.3.6 emergency lighting – lighting provided for use when the supply to the normal lighting fails. [SOURCE: ISO 30061:2007, 4.1] 560.3.7 emergency lighting luminaire – luminaire which may or may not be provided with its own electrical source for safety services and which is used for safety or emergency lighting. 560.3.8 escape sign luminaire – luminaire that indicates and assists the identification of escape routes. 560.3.9 maintained mode – operating mode of a lighting system in which the emergency lighting lamps are energized at all times when normal or emergency lighting is required. 560.3.10 non-maintained mode – operating mode of a lighting system in which the emergency lighting lamps are in operation only when the supply to the normal lighting fails. 560.3.11 response time – time that elapses between the failure of the normal power supply and the electrical source for safety services energizing the equipment. 560.3.12 central power supply system – system which supplies the required emergency power to essential safety equipment. 560.3.13 escape route – route to follow for access to a safe area in the event of an emergency. 560.3.14 preferential circuit – circuit derived directly from the incoming supply to the building intended to supply safety
--	---

тэжээж эхлэх хүртэлх хугацаа. 560.3.12 төвлөрсөн цахилгаан хангамжийн систем – зайлшгүй аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжийг шаардлагатай ослын цахилгаан эрчим хүчээр хангах систем. 560.3.13 нүүлгэн шилжүүлэх зам – ослын үед аюулгүй бүсэд хүрэхээр дагаж явах зам. 560.3.14 давуу эрхтэй хэлхээ – барилгын оролтын тэжээлээс шууд салбарлан аюулгүй ажиллагааны үйлчилгээг тэжээх бөгөөд ослын үед аль болох удаан ажиллагаатай байх хэлхээ. 560.3.15 хамгийн бага гэрэлтүүлэг – ослын гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааны нийт хугацаанд хангах гэрэлтүүлэг. 560.3.16 аюулгүй ажиллагааны үйлчилгээ – аюул үүссэн үед хүмүүсийг хамгаалах буюу анхааруулах эсхүл тухайн байршлаас нүүлгэн шилжүүлэхэд зайлшгүй шаардлагатай цахилгаан тоног төхөөрөмжийн цахилгаан систем. ЖИШЭЭ: ослын (нүүлгэн шилжүүлэх) гэрэлтүүлэг; галын насос; гал унтраах, аврах ажиллагааны лифт; галын, СО болон халдлагын дохиолол; нүүлгэн шилжүүлэх систем; утаа зайлуулах систем; эмнэлгийн зайлшгүй систем. Бичилтийн 1-р тайлбар: Аюулгүй ажиллагааны үйлчилгээ нь гал буюу аюулыг эхний шатанд илрүүлэх, галын тархалтыг хязгаарлах ба унтраах, утааг хянах, аюулгүй бөгөөд үр дүнтэй нүүлгэн шилжүүлэлтийг хангах зориулалттай. 560.3.17 галын нөхцөл – ISO 834-1-ийн температур-хугацааны муруйгаар эсхүл орон нутгийн хууль тогтоомжоор тодорхойлсон нөхцөл. 560.3.18 тохирох байршил – галын нөхцөлд тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах хийцийн бүрхүүл, тусдаа галд хамгаалагдсан тасалгаа эсхүл өрөө. 560.3.19 галын унтраалга – галын үед ажиллах шаардлагатай тоног төхөөрөмжийг тэжээх хэлхээнээс бусад бүх хэлхээг салгахад ашиглах цахилгаан аппарат. Бичилтийн 1-р тайлбар: Угсралт ба үзүүлэлтийг D хавсралтад	services which, in case of emergency, shall remain in operation for as long as possible. 560.3.15 minimum illuminance – illuminance for emergency lighting throughout the whole rated operating time. 560.3.16 safety service – electrical system for electrical equipment provided to protect or warn persons in the event of a hazard, or essential to their evacuation from a location. EXAMPLE: emergency (escape) lighting; fire pumps; fire rescue services lifts; alarm systems; evacuation systems; smoke extraction systems; essential medical systems. Note 1 to entry: Safety services is equipment installed in buildings to detect fire or danger in its initial stage, also limit fire spread and extinguish fire and control smoke and enable safe and effective evacuation. 560.3.17 fire condition – condition defined by the temperature-time curve of ISO 834-1, or by local legislation. 560.3.18 suitable location – constructional enclosure or separate fire protected compartment or room ensuring normal operation of equipment under fire conditions. 560.3.19 fire switch – electrical apparatus, which shall be used to disconnect all circuits with the exception of circuits supplying the equipment whose operation during a fire is necessary. Note 1 to entry: The installation and characteristics of fire switch are described in Annex D (informative). Note 2 to entry: The switch could be a circuit breaker or disconnector.
---	---

тайлбарласан. Бичилтийн 2-р тайлбар: Унтраалга нь таслуур эсхүл салгуур байж болно.	
560.4 Ангилал 560.4.1 Аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан хангамжийн систем нь операторын үйлдлээр асаах автомат бус хангамжийн систем эсхүл оператороос үл хамааран асаах автомат хангамжийн систем байна. Автомат системийг хамгийн их шилжилтийн хугацаагаар: А – тасалдалгүй; В – маш богино тасалдал, 0,15 s; С – богино тасалдал, 0,5 s; D – дундаж тасалдал, 5 s; E – дунд зэргийн тасалдал, 15 s; F – урт тасалдал, 15 s-ээс их гэж ангилна. 560.4.2 Аюулгүй ажиллагааны үйлчилгээний зайлшгүй тоног төхөөрөмж тогтоосон ажиллагааг хадгалахын тулд 560.4.1-д заасан зохих ангид хамаарсан байна.	560.4 Classification 560.4.1 An electrical supply system for safety services is either a non-automatic supply system, the starting of which is initiated by an operator, or an automatic supply system, the starting of which is independent of an operator. An automatic supply system is classified according to maximum changeover time: class A no-break; class B very short break within 0,15 s; class C short break within 0,5 s; class D average break within 5 s; class E medium break within 15 s; class F long break in more than 15 s. 560.4.2 The essential equipment for safety services shall be within the specified class according to 560.4.1 in order to maintain the specified operation.
560.5 Ерөнхий шаардлага 560.5.1 Аюулгүй ажиллагааны үйлчилгээ нь үндсэн болон орон нутгийн тэжээл тасарсан үед, мөн галын нөхцөлд шаардлагатай бүх хугацаанд ажиллах шаардлагатай байж болно. Иймд тусгай эх үүсвэр, тоног төхөөрөмж, хэлхээ, утас кабель шаардлагатай. 560.5.2 Галын нөхцөлд ажиллах аюулгүй ажиллагааны үйлчилгээнд давуу эрхтэй хэлхээнээс бусад тохиолдолд хангалттай хугацааны тэжээл хадгалах нэг буюу хэд хэдэн цахилгаан эх үүсвэртэй байна; мөн бүх тоног төхөөрөмж галын нөхцөлд хангалттай хугацаанд хэвийн ажиллах галын хамгаалалттай байна. ТАЙЛБАР 1 – Тоног төхөөрөмжид эх үүсвэр, тэжээлийн дамжуулагч, кабель удирдлагын систем, холболтын хайрцаг орно. ТАЙЛБАР 2 – Аюулгүй ажиллагааны эх үүсвэр нь ихэвчлэн хэвийн эх үүсвэрт нэмэлт байна. ТАЙЛБАР 3 – Орон нутгийн хууль тогтоомж үйлчилж болно. 560.5.3 Эхний гэмтлийн үед тэжээлийг таслахгүй байх шаардлагатай бол IT системийг давуу хэрэглэнэ. Эхний гэмтэлд дуут ба харагдах дохио өгөх	560.5 General 560.5.1 Safety services may be required to operate at all relevant times including during main and local supply failure and through fire conditions. To meet these requirements, specific sources, equipment, circuits and wiring are necessary. 560.5.2 For safety services required to operate in fire conditions, one or more electrical sources for safety services shall be provided to maintain a supply of adequate duration, except for preferential circuits, and all equipment of safety services shall be provided with fire protection ensuring normal operation in fire conditions of adequate duration. NOTE 1 Equipment includes power sources, feeder conductors, cable management systems, junction boxes. NOTE 2 The electrical source for safety services is generally additional to the normal supply source. NOTE 3 Local legislation can apply. 560.5.3 An IT system is preferred where non-disconnection on the first fault is required. Insulation monitoring devices shall give audible and visible indication in the event of a first fault. 560.5.4 A failure in the control or bus

тусгаарлагын хяналтын төхөөрөмж суурилуулна. 560.5.4 Аюулгүй ажиллагааны бус байгууламжийн удирдлага буюу шинийн системийн гэмтэл нь аюулгүй ажиллагааны үйлчилгээний зөв ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй.	systems of the non-safety services installation shall not adversely affect the proper function of safety services.
560.6 Аюулгүй ажиллагааны үйлчилгээний цахилгаан эх үүсвэр 560.6.1 Хүлээн зөвшөөрөх эх үүсвэр: хуримтлуурын батарей; анхдагч элемент; хэвийн тэжээлээс үл хамаарах генераторын агрегат; хэвийн тэжээлийн шугамаас үр дүнтэй үл хамаарах тэжээлийн сүлжээний тусдаа шугам. 560.6.2 Эх үүсвэрийг суурин тоног төхөөрөмжөөр угсарч, хэвийн эх үүсвэрийн гэмтэл түүнд сөргөөр нөлөөлөхгүй байлгана. 560.6.3 Эх үүсвэрийг тохирох байршилд суурилуулж, зөвхөн BA5 эсхүл BA4 хүн нэвтрэх боломжтой байна; бусад эх үүсвэрээс тусгаарлавал зохино. Гал, үер, хөлдөлт, санаатай эвдрэл болон бусад сөрөг нөхцөлийн аюулыг хамгийн бага байлгахгаар зураг төсөллөж байрлуулна. ТАЙЛБАР – G хавсралтыг үз. 560.6.4 Байршлыг зохих ёсоор агааржуулж, яндангийн хий, утаа, уур хүн байрладаг хэсэгт нэвтрэхгүй байлгана. 560.6.5 Хоёр тэжээл зэрэг гэмтэх магадлал бага гэдгийг баталгаажуулж чадахгүй бол тэжээлийн сүлжээний тусдаа шугамыг эх үүсвэр болгон ашиглахгүй. 560.6.6 Эх үүсвэр нь холбогдох үйлчилгээг тэжээх хангалттай чадалтай байна. 560.6.7 Аюулгүй ажиллагааны бэлэн байдлыг дордуулахгүй бол эх үүсвэрийг бусад зориулалтаар ашиглаж болно; бусад хэлхээний гэмтэл аюулгүй ажиллагааны хэлхээг таслахгүй. 560.6.8 Зэрэгцээ ажиллах боломжгүй эх үүсвэрүүдийг зэрэгцээ холбохоос сэргийлнэ; эх үүсвэр бүр богино залгаа ба гэмтлийн хамгаалалттай байна.	560.6 Electrical sources for safety services 560.6.1 Recognized sources: storage batteries; primary cells; generator sets independent of the normal supply; a separate feeder of the supply network effectively independent of the normal feeder. 560.6.2 The source shall be fixed and not adversely affected by failure of the normal source. 560.6.3 It shall be in a suitable location accessible only to BA5 or BA4 persons; sources should be segregated. Hazards such as fire, flooding, freezing and vandalism shall be minimized. NOTE See Annex G. 560.6.4 The location shall be adequately ventilated. 560.6.5 Separate feeders shall not serve as sources unless concurrent failure is unlikely. 560.6.6 The source shall have sufficient capability. 560.6.7 It may serve other purposes if safety-service availability is not impaired. 560.6.8 Sources not capable of parallel operation shall be prevented from paralleling and each source shall have short-circuit and fault protection. 560.6.9 Parallel-capable sources may require special devices such as reverse-power protection; protection shall be provided for separate or parallel supply and neutral circulating current shall be limited. 560.6.10 Central power supply batteries shall be vented or valve-regulated, reduced-maintenance, heavy-duty industrial design; minimum design life at 20 °C is 10 years. 560.6.11 UPS requirements include

560.6.9 Зэрэгцээ ажиллах боломжтой эх үүсвэрт буцах чадлаас сэргийлэх зэрэг тусгай төхөөрөмж шаардагдаж болно. Нийтийн тэжээлтэй зэрэгцээ ажиллуулахад тэжээгч байгууллагын зөвшөөрөл шаардагдаж болно. Аль нэг эх үүсвэрээр эсхүл хоёуланг зэрэгцээгээр тэжээхэд гэмтэл ба богино залгааны хамгаалалт хийнэ. Саармаг цэгүүдийн хооронд гүйдэл эргэлдэх, ялангуяа гуравдагч гармоникийн нөлөөг хязгаарлана. 560.6.10 Төвлөрсөн системийн батарей нь хий ялгаруулдаг эсхүл хавхлагатай зохицуулалттай, засвар үйлчилгээ багатай, хүнд нөхцөлийн үйлдвэрийн хийцтэй байна. 20 °C-д зураг төслийн хамгийн бага ашиглалтын хугацаа 10 жил байна. 560.6.11 UPS нь ачааллын талын хамгаалах төхөөрөмжүүдийг ажиллуулах, ослын нөхцөлд аюулгүй ажиллагааны үйлчилгээг асаах, холбогдох стандартуудыг хангах, тэжээлийн дээд талын эх үүсвэрээс үл хамааран асах чадвартай байна. 560.6.12 Дизель хөдөлгүүртэй аюулгүй ажиллагааны генераторын агрегат ISO 8528-12-т нийцнэ. 560.6.13 Эх үүсвэрийн төлөвийг хянаана.	operation of downstream protective devices, starting safety services in emergency, applicable compliance with 560.6.10 and IEC 62040 parts, and independent start. 560.6.12 Diesel engine driven safety generating sets shall comply with ISO 8528-12. 560.6.13 The source condition shall be monitored.
